# ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Э.Ууганбаяр
Удирдлагын академийн Онцгой байдлын
удирдлага-стратегийн профессорын багийн
дэд профессор, хошууч

Ж.Энхтөр
Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны
магистрант, ахмад

***Товч агуулга.*** Энэхүү судалгааны ажилд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах ангийн үйлчлэх хүрээ, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, гал түймэр унтраах үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд Гал түймэр унтраах, аврах ангийн чадавх цаашлаад түүний үйлчлэх хүрээг тогтоож буй арга, стандарт үзүүлэлтүүд чухал нөлөөтэй болохыг тогтооход оршино.

***Түлхүүр үгс.*** Гал түймэр, гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа, стандарт, удирдлага зохион байгуулалт.

## Оршил

Монгол Улсын хэмжээнд гарч буй объектын томоохон хэмжээний, хохирол ихтэй гал түймрийн хор уршгийг оновчтой тодорхойлон тактикийн өндөр түвшинд унтраах, Онцгой байдлын байгууллагын Гал түймэртэй тэмцэх арга зам, Удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож сайжруулах цаашдын бодлого, тактикийн боловсронгуй нэмэлт шаардлагатай арга хэмжээг бий болгоход оршино.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын төлөвлөлтийн асуудал нь ихэнх салбарт эрсдэл учруулах эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байгаа билээ. Ялангуяа хот суурин газрын барилгажилт, барилга хоорондын галын аюулгүйн зай хэмжээ зөрчигдөх, гал түймэр унтраах гадна усан хангамжийн нормчилсон хэмжээслэл алдагдах, шуурхай үеийн дуудлагаар ажиллах үед авто замын түгжрэл үүсэх зэрэг хүндрэлүүдийг дагалдан гал түймрийг унтраах үйл ажиллагааг богино хугацаанд оновчтой, үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл учруулж байна.

### Нэг. Гал түймэр унраах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өмчийн харъяалал харгалзахгүйгээр төр, байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн амь бие, эд хөрөнгө, байгалийн баялагийг гал түймрийн аюулаас авран хамгаалах үүрэгтэй.

Гал түймрийн болзошгүй аюулаас төр, байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн өмч хөрөнгө, хүний амь бие, байгалийн баялагийг авран хамгаалах Тамшгаас хамгаалах тухай” болон Талын аюулгүй байдлын тухай” Монгол Улсын

хуулиудыг хэрэгжүүлэх нь Онцгой байдлын байгууллагын албан хаагч нэг бүрийн үүрэг мөн.

*Галын аюулгүй байдлын тухай хуулинд:*

“гал түймэр” гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;[1]

“гал түймэр унтраах” гэж гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагааг;[2]

Манай орны хувьд обьектын гал түймэр нь цар хүрээ, үргэлжлэх хугацаа бага ч нийт тохиолдож буй гамшиг ослын 80-90 орчим хувь, хохиролын 50 гаруй хувийг эзэлж давтамж болон хохирол их, хүн ам ихээр суурьших барилга байгууламжид үүсэн бий болж байгаа нь өнөөдөр гамшгаас хамгаалах менежмент болон гал түймрийн аюулын эрсдлийг бууруулах менежментийг зөв төлөвлөн зохион байгуулах зүй ёсны шаардлага урган гарч байна.

**Хоёр. Объектын гал түймрийн нөхцөл байдал.**

Манай оронд сүүлийн жилүүдэд гал түймрийн хэрэг, зөрчил өсч улс орны үндэсний болон эдийн засгийн хямралын байдал, иргэдийн амьдрал, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаанд бодит бэрхшээл учруулж байна.

Олон жилийн дундажаас үзэхэд манай улсын хэмжээнд гарч буй гамшгийн 90 хувь, хохиролын 70-80 хувийг обьектын гал түймэр эзэлж байна.

Монгол улсын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт **15141** удаагийн гал түймэр бүртгэгдэж, жилд дунджаар 3028 удаагийн гал түймрийн улмаас улс орны нийгэм эдийн засагт **141,9** тэрбум төгрөгийн хохирол учирч, гал түймрийн улмаас 162 хүн амь насаа алдсан байна.

Гал түймрийн аюулаас Онцгой байдлын байгууллагын алба хаагчид нийт 2605 эрдэнэт хүний амь насыг авран хамгаалж, төрийн болон иргэн хуулийн этгээдийн 227 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

Улсын хэмжээнд 2021 он 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар обьектын гал түймрийн 2267 тохиолдол */гал түймэр унтраах анги ажиллаж унтраасан* 1343, *зөрчил* 757, *мэдээлэл 1671* бүртгэгдэж гал түймрийн аюулаас **103** иргэний */том хүн 87, хүүхэд 16/ амь насыг аварч, гал түймэрт 56 иргэн/том хүн 38, хүүхэд 13, өөрийгөө шатаасан 5 том хүн/* өртөж нас барж, 33 иргэн */том хүн 30, хүүхэд 3/* түлэгдсэн, 34 иргэн */27 том хүн, 7 хүүхэд/* угаартсанаас, 1 том хүн угаартаж нас барж, 1008 мал */бод 4, бог 1004/* хорогдсон.[3]

Объектын гал түймрийн дуудлага, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гал түймрийн тоо 28 хувиар, гал түймэрт өртөж нас барсан иргэд 12 хувиар, учирсан хохирол 21 хувиар буурсан үзүүлэлттэй байна. *Зураг 1, 2, 3-т графикаар харуулсан.*

[1] Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зуйлийн 3.1.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл 2019 №28

[2] Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл 2019 №28

[3] ОБЕГ-ын 2021 оны жилиийн эцсийн тайлан

**Зураг 1. Объеътын гал түймрийн тоо. 2020-2021 оны харьцуулалт**




**Зураг 2. Гал түймрийн улмаас учирсан хохирол. 2020-2021 оны харьцуулалт**




**Зураг 3 Гал түймрийн улмаас нас барсан хүний тоо. 2020-2021 оны харьцуулалт**



## Гурав. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал.

2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар Булган, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Ховд, Өвөрхангай, Архангай зэрэг 9 аймгийн 31 суманд нийт 58 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдсэн. Дээрх түймэрт урьдчилсан байдлаар ойн 1789 /га/, хээрийн 305,469.93/га/ нийт 307,258.93/га/ талбай өртөж, байгаль, экологид 1,238,624,031,1 төгрөгийн хохирол учирсан байна. Монгол Улсын хилийн 3 удаагийн хээрийн түймэр БНХАУ-ын хил давсан. Ой хээрийн гал түймрийн дуудлагын тоог 2020 оны мөн үетэй харьцуулахад 75,2% -иар буурсан байна.

Ой, хээрийн түймэр унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагаас 596 алба хаагч, 61 автомашин, Хил хамгаалах байгууллагаас 176 алба хаагч, 26 автомашин, Орон нутгаас 1141 иргэн, 188 автомашин, 45 мотоцикл, 20 морь, нийт 1893 хүн, 317 автомашинтай ажилласан байна.-

**Зураг 4. Ой хээрийн түймрийн судалгаа. 2020-2021 оны харьцуулалт**




**Зураг 5. Учирсан хохирлын хэмжээгээр:**







[4] ОБЕГ-ын 2020-2021 оны жилиийн эцсийн тайлан

## Дөрөв. Гал түймэр унтраах, ангийн үйлчлэх хүрээний норм, стандарт, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам.

Гал түймрийг унтраах аврах ангийн чадавх цаашлаад түүний үйлчлэх хүрээ болон үйлчлэх хүрээг тогтоож буй арга, стандарт үзүүлэлтүүд чухал нөлөөтэй тул түүнийг тусгайлан судалж сайжруулах арга замыг замыг тодорхойлох зайлшгүй шаардлага байна. Иймээс орчин үед, гал түймэр унтраах, аврах ангийн төлөвлөлт, нийгэм, эдийн засаг, орчны бусад асуудалтай уялдуулан судлах, тооцох асуудал нэн чухал шаардлагатай байна.

Монгол улсын хүн амын 51% нь Улаанбаатар хотод амьдарч байгаа ба хот суурин газрын хүн амын аюулгүй байдлыг хамгаалах, цаашлаад улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн үүргийг Онцгой байдлын байгууллага ханган ажиллаж байна. Иймд гарсан гал түймрийг богино хугацаанд, хохирол багатай унтраах асуудал нь тухайн хүн амын харьцуулалтанд үйлчлэх гал түймэр унтраах, аврах ангийн хүн, хүч техник хэрэгслийн бэлтгэл бэлэн нэн шаардлагатай.

Аймаг, нийслэл, сум дүүргийн тоо, нягтрал, үйлдвэржилт, дэд бүтэц, галын аюултай объектын цар хүрээ, онцлог, гал түймэр, гамшгийн давтамж зэргээс хамаарч гал унтраах анги, хэсгийг ба гал унтраах зориулалтын албаны автомашины тоог тодорхойлж өгсөнийг хүснэгт 6-т тусгаж өгсөн.

**Хүснэгт 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гал унтраах анги, хэсгийн автомашины тоо.[5]**

| Аймаг, нийслэл, сум, дүүргийн хүн ам | Гал унтраах ангийн үндсэн албаны автомашин /тоогоор/ | Гал түймэр унтраах, аврах ангийн тоо |
|---|---|---|
| 4000-6000 хүртэл | 1 | 1 |
| 6001-10000 хүртэл | 2 | 1 |
| 10001-15000 хүртэл | 2-5 | 1 |
| 15001-20000 хүртэл | 2-5 | 1-2 |
| 20001-50000 хүртэл | 4-10 | 1-2 |
| 50001-100000 хүртэл | 7-15 | 3-4 |
| 100001-500000 хүртэл | 10-50 | 5-10 |
| 500001-800000 хүртэл | 33-53 | 10-15 |

[5]Монгол улсын стандарт гал унтраах анги хэсэг, аврах нэгжид тавих шаардлага. MNS6412-2013.

| | | |
|---|---|---|
| 800001-1000001 хүртэл | 50-56 | 16-18 |
| 1000001-1250000 хүртэл | 53-65 | 18-24 |
| 1250001-2000000 хүртэл | 56-80 | 24-36 |

Нийслэл Улаанбаатар хотын бүтцийн нэгжийн Онцгой байдлын хэлтсүүдийн гал түймэр унтраах, аврах ангиудын үйлчлэх хүрээн хүн амын судалгаа болон гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын тоог, стандарт[6] нөхцөл байдалтай харьцуулсан судалгааг хүснэгт 2-т заасан.

**Хүснэгт 2. Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын судалгаа**

| д/д | Дүүргүүд | Хүн амын тоо | Стандартад байх Гал унтраах автомашины Тоо | Одоо байгаа Гал унтраах автомашины тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Чингэлтэй дүүрэг | 148977 | 20 | 8 |
| 2 | Сүхбаатар дүүрэг | 164409 | 18 | 5 |
| 3 | Хан-Уул дүүрэг | 187278 | 17 | 7 |
| 4 | Сонгино-Хайрхан дүүрэг | 327580 | 31 | 8 |
| 5 | Баянзүрх дүүрэг | 361629 | 34 | 6 |
| 6 | Баянгол дүүрэг | 255840 | 24 | 4 |
| 7 | Налайх дүүрэг | 37659 | 8 | 4 |
| 8 | Багануур дүүрэг | 28570 | 5 | 3 |
| 9 | Багахангай дүүрэг | 4123 | 2 | 3 |
| Нийт дүн | | 1.540.000 | 159 | 48 |

Гал түймэр унтраах, аврах ангиудын гамшгийн үед үүрэг гүйцэтгэх хүн хүч, техникийн хүчин чадал нь тогтоосон стандарт шаардлагыг хангахгүй байна.

Дээрхээс дүгнэж үзэхэд обьектын гал түймрийг унтраахад тулгамдаж буй асуудлуудыг авч үзвэл.

Судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд объектын гал түймрийн тоо жил тутам өссөн дүнтэй байх ба үүнтэй уялдаад нэг гал түймрийн тоо жил тутам өссөн дүнтэй байх ба үүнтэй уялдаад нэг Гал түймэр унтраах, аврах ангид ноогдох гал түймрийн ачаалал өссөөр байна. Ялангуяа Нийслэлд гарч буй объектын гал түймрийн тоо нэмэгдэх хандлагатай байсаар байна. Объектын гал түймэр нь хүний

[6]CS11-0115-2010 стандарт

санамсар болгоомжгүй болон санаатай үйлдэлтэй үйлдэлтэй холбоотойгоор гардаг техногены шинжтэй учир хүн амын өсөлттэй шууд хамааралтай байдаг нь олон улсын болон Монгол улсын практикаас ажиглагддаг.

Хүмүүсийн хангагдаагүй хэрэгцээ, хэрэгжээгүй шаардлага, үнэт зүйл, нөгөөтэйгүүр тэдгээрийг төрийн бодлогоор шийдэх боломжийг бодлогын асуудал гэнэ. Галын аюулгүй байдлын тухай хууль болон галын стандарт норм дүрмээр аливаа барилга байгууламжийг галын дохиололын системээр тоноглогдсон байхыг шаардаж, улмаар барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч байгаа ч уг тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагатай хэрхэн холбох, хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өнөөдөр төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай байна.

Өнөөдөр манай орны хувьд Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, улмаар дэлхийн бусад улсуудын нийтлэг жишигт хүргэх, түүний удирдлага, зохион байгуулалтад шинэ техник технологийг нэвтрүүлэх явдал нь бодит амьдралаас урган гарч байна.

Иймд түүнийг богино хугацаанд, хохирол зардал багатай унтраах асуудал нь Гал түймэр унтраах, аврах ангийн чадавх, ачаалалтай шууд хамааралтай. Дээрх нөхцөл байдлын үндсэн дээр Гал түймэр унтраах, аврах ангийн чадавх ачаалалыг харгалзсан түүний үйлчлэх хүрээний асуудлын талаарх онол арга зүйн асуудлыг шинжлэв.[7]

Онцгой байдлын мэргэжлийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэхийн тулд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нийгмийн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх, олон нийт хамтын ажиллагааг бодитойгоор идэвхижүүлэн, шинэ шатанд гаргана гэж үзэж байна.

[7] Гал түймэр унтраах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам. 2019 он

## Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд Гал түймэр унтраах, аврах ангиудын байршил зохион байгуулалтыг, стандарт шаардлагад нийцүүлэн ажиллах, хүн амын тоотой уялдуулан хүн хүч, техник хэрэгсэлээр хангах зайлшгүй шаардлага байгаа нь ажиглагдлаа. Гал түймэр унтраах, аврах ангийн зэрэглэлийг тогтоохдоо гал түймэр унтраах зориулалтын техникийн үндсэн үзүүлэлт бие бүрэлдэхүүнийг шаардлагатай хүн хүчээр хангах талаар анхаарч ажиллах, тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж, гал унтраах ангиудын зэрэглэлийг тогтоосон шйидвэрийг улсын стандарт шаардлагад нийцүүлж гаргаж байх нь зүйтэй.

Гал түймэр унтраах, аврах анги нь үйл ажиллагаа явуулах зориулалтын байр, албаны бэлтгэл бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн болон бие бялдарын тэсвэр хатуужлыг хөгжүүлэх, гал унтраах дасгал сургуулилт явуулах тусгай байгууламж бүхий эзэмшил газар талбайтай байна гэж заасан боловч газар өмчлөл болон дүрэм стандартаа төдийлөн дагаж мөрдөж чаддаггүй байна.

Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуульд гал түймрийн аюулаас хамгаалах арга хэмжээг нутаг дэвсгэр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэртэй хамааруулан ашиглаж зарцуулахдаа норм, дүрэм, стандартыг баримтлан авч хэрэгжүүлэх хэрэгтэй[8].

## Санал

Дээрхи тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна.

Гал түймэр унтраах, аврах ангийн үйлчлэх хүрээ нь тухайн орон нутгийн онцлог, хүн амын нягтрал, барилга байгууламжаас хамаарч гал унтраах үйл ажиллагаа явуулах боломжит зай хэмжээнээс хамаарна гэж MNS6412:2013 стандартад тусгасан байдаг боловч дээрх шинжилгээнээс үзвэл Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох норм, нормативын баримт бичгүүдэд тусгагдаагүй байдлыг авч хэрэгжүүлэх. Учир нь тухайн дүрэм, норм стандартууд нь хэт нэг талыг баримталсан бодит амьдралд бууж хэрэгжиж ажиллаж чадахгүй байгаа нь шийдвэрлэх гол шалтгаан юм.

[8] С.Баттөмөр., Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага., УБ., 2019 он.

**Эх сурвалжийн жагсаалт:**

Галын аюулгүйн байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2015. 2019 он.№28.
Гал түймэр унтраах дүрэм., 2016.
Монгол улсын стандарт MNS6412-2013.
Баттөмөр С., Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага., УБ., 2019.
СэржмядагД., Гамшгаас хамгаалах менежментийн үндэс., УБ., 2017.
Гал түймэр унтраах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам судалгааны эмхэтгэл., УБ., 2019 он.